



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 05 сарын 06 өдөр

Дугаар A/36

Улаанбаатар хот

### Г “Аялал жуулчлал ба ажил эрхлэлт-2015” Г хөдөлмөрийн яармаг зохион байгуулах тухай

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний 3.4.1.7 дахь заалт, тус газрын дүрмийн 2.3, 3.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аялал жуулчлалын салбарын боловсон хүчнийг бэлтгэх, ажлын байраар хангах зорилготой “Аялал жуулчлал ба ажил эрхлэлт” хөдөлмөрийн яармагийг зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөдөлмөрийн яармагийн төсөв болох 1.044.700 /нэг сая дөчин дөрвөн мянга долоон зуу/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.


3. Хөдөлмөрийн яармагийг удирдамжид заасан хугацаанд зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг дотоодын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн /Н.Алтанзаяа/-д даалгасугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн аялал жуулчлалын газрын  
даргын 2015 оны 05 сарын 06-дрийн АТЗС  
тоот тушаалын нэгдүгээр хавсралт



## **“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ БА АЖИЛ ЭРХЛЭЛТ- 2015” ХӨДӨЛМӨРИЙН ЯАРМАГИЙН УДИРДАМЖ**

### **Нэг. Зорилго:**

Аялал жуулчлалын салбарт ажиллах сонирхолтой оюутан залуус, идэвхтэй ажил хайгч иргэдийг эзэмшсэн мэргэжлийн дагуу түр болон байнгын ажлын байртай болох нөхцөлийг хангах, аялал жуулчлалын байгууллагуудад шаардлагатай байгаа мэргэжлийн ажилтнаа олоход нь дэмжлэг үзүүлэх, ажил олгогч, ажил хайгч иргэдийг холбоход оршино.

### **Хоёр. Ерөнхий зохион байгуулагч:**

- Нийслэлийн Аялал жуулчлалын газар

### **Гурав. Хамтран зохион байгуулагч**

- Нийслэлийн Хөдөлмөрийн газар
- Аялал жуулчлалын багш судлаачдын нийгэмлэг

### **Дөрөв. Хугацаа, байршил:**

2015 оны 05 дугаар сарын 08-ны өдөр 10:00-17:00 цагийн хооронд Нийслэлийн Засаг захиргааны 4-р байрны 2-р давхар буюу “Улаанбаатар Бизнес хөгжлийн төв”-ийн үзэсгэлэнгийн танхимд

### **Тав. Хамрах хүрээ:**

- Аялал жуулчлалын их, дээд сургуулийн оюутнууд
- Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний мэргэжлээр төгсөгчид
- Ажил идэвхтэй хайж буй иргэд

### **Зургаа. Ажил олгогчид:**

Тур оператор, жуулчны бааз, зочид буудал, дэн буудал, амралтын газар, зоогийн газар бусад аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагууд

### **Долоо. Яармагийг зохион байгуулах байгууллагуудын үүрэг оролцоо:**

*Нийслэлийн аялал жуулчлалын газар:*

- Хөдөлмөрийн яармагийн удирдамж, төсвийг боловсруулж, холбогдох зардлыг гаргах,
- Ажлын байрны захиалгатай аж ахуйн нэгж, иргэдийг оролцуулах,
- Хөдөлмөрийн яармагийн бэлтгэл ажлыг хангах
- Хөдөлмөрийн яармагийн талаарх мэдээллийг түгээх

*Нийслэлийн хөдөлмөрийн газар:*

- Ажлын байр зарлах,
- Дүүргүүдийн Хөдөлмөрийн хэлтэсүүдийг оролцуулах,
- Яармаг зохион байгуулах танхим бэлтгэх,
- Хөдөлмөрийн яармагийн талаарх мэдээллийг холбогдох газруудад мэдээллэх

*Аялал жуулчлалын багш судлаачдын нийгэмлэг*


- Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг их дээд сургуулиудад хөдөлмөрийн яармагийн мэдээллийг хүргэх
- Оюутнуудын оролцоог хангах

**Найм. Зохион байгуулагдах үйл ажиллагаа:**

- 2015 оны аялал жуулчлалын улиралд салбарын байгууллагуудад хэрэгцээтэй байгаа ажлын байрыг нийтэд зарлах
- Ажил олгогч болон нээлттэй ажлын байрны зар мэдээллийг түгээх, сурталчлах
- Аялал жуулчлалын салбарын ажил мэргэжлийн онцлог, шаардагдах мэдлэг ур чадваруудын талаарх видео хичээл, танилцуулгыг хийх
- Аялал жуулчлалын салбарт ажил мэргэжлээрээ амжилт гарган ажиллаж буй хүмүүсээр дамжуулан 5-10 минутын лекц танилцуулга хийх

**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**  
Утас: 70148687, 91666064,

Нийслэлийн аялал жуулчлалын газрын  
даргын 2015 оны 05 сарын 06 дрийн 436  
тоот тушаалын хоёрдугаар хавсралт



**“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ БА АЖИЛ ЭРХЛЭЛТ-2015”  
ХӨДӨЛМӨРИЙН ЯАРМАГ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ЗАРДЛЫН ТӨСӨВ**

Д/д	Зардлын зүйл	Тоо ширхэг	Хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт
1	Шторк	1	15секунд	770000	770000
2	Анонс хаяг хэвлүүлэх	1	5м:3,4м	5500	93500
3	Плакат	20	A3	2500	50000
4	Босоо анонс	2	0,8м:1,8м	18000	52000
5	Анонс /хөмсгөн хаяг/	50	3м:20см	5500	79200
<b>НИЙТ</b>					<b>1.044.700</b>

Хянасан: Ахлах нягтлан бодогч

П.Ариунаа

Боловсруулсан: Мэргэжилтэн

Н.Алтанзаяа